

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Орхон сумын Засаг даргын Тамгын газар

2025.12.16

Орхон

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын албан даалгавар							
2	16	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03	1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоо үе шаттай цөөлөх	Орон нутгийн төсвийн 2025 оны жилийн эцсийн татварын орлого 14 нэр төрлийн 973.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 974.0 сая төгрөг, татварын бус орлого 15.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 17.0 сая тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 988.9 сая төгрөгийн 991.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, гүйцэтгэл 100.2 хувь биелүүллээ. Сумын ЗДТГ-ын төрийн жинхэнэ албан тушаалын 4 сул орон тоог сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүргүүлэхээс өмнө төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс 6 удаа цахим хэлбэрээр 5 хоногийн хугацаатайгаар нийтэд зарлаж уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг мэдээллээр хангасан. Сул ажлын байранд сонгон шалгаруулалтгүйгээр хууль зөрчин томилсон үйлдэл гараагүй ба төрийн үйлчилгээний 1 орон тоо сул бөгөөд хэмнэлтийн горимын дагуу нөхөөгүй байна.	100	-	-

21		<p>1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах</p>	<p>МУ-ын Хэмнэлтийн тухай хуулийн дагуу батлагдсан төсвийг хуваарийн дагуу үр ашигтай зарцуулж 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЗДТГ-ын тогтмол зардлаас 19.6 сая төгрөг хэмнэлээ. Төсвийн тодотгооор сумын ЗДТГ-аас Хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж 119.4 сая төгрөг тэвчиж аймгийн санхүүд төвлөрүүлсэн.</p>	100	-	-
23		<p>2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах</p>	<p>www.orkhon.da.gov.mn болон “Орхон сумын Засаг даргын Тамгын газар” фейсбүүк хуудсанд төрийн байгууллагын дарга эрхлэгч нарын нэр, албан тушаал, утасны дугаарыг 1 удаа байршууллаа.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 5 төрлийн 87 мэдээг улирал тутам хугацаанд нь shilen.gov.mn сайтад байршуулж нийтэд мэдээлэл хүргэсэн. Хөндлөнгийн үнэлгээгээр тус ЗДТГ-ын шилэн дансны мэдээллийн үйлчилгээ хувьтай 98.5 хувьтай үнэлэгдлээ.</p>	100	-	-
25		<p>3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх</p>	<p>Тус сумын ЗДТГ-аас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг нийт 15 удаа явуулж БОНБУ-ний тухай хууль зөрчсөн 5 ААН, ойн тухай хууль зөрчсөн 3, амьтны тухай хууль зөрчсөн 4, усны тухай хууль зөрчсөн 1 удаагийн зөрчлийг илрүүлж Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож зөрчлийг арилгуулж, хохирлыг барагдуулах арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Сумын Засаг даргын 2025 оны 01-А/32 дугаар захирамжаар сэг зэм устгах ажлыг зохион байгуулах 7 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон ажлын хэсэг зүй бусаар хорогдсон адуу 28, үхэр 83, хонь 50, ямаа 45 нийт 206 малын сэг зэмийг төвлөрсөн 2 хогийн цэг тээвэрлэн, булж устгаж, 3500 м.кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.</p>	100	-	-

			<p>Суманд авто тээврийн хэрэгслийн үзлэг зохион байгуулж сумын хэмжээнд 486 авто тээврийн хэрэгсэл оношилгоонд хамрагдсан.</p> <p>Орхон хаалгаас сумын төв чиглэлийн авто замын эвдрэл гэмтэлийг аймгийн Засаг даргын 7.0 сая төгрөгийн дэмжлэгээр, өөрсдийн хөрөнгөөр 1.2 сая төгрөгөөр тус тус засварлаж, 8 тэмдэг тэмдэглэгээг 1.2 сая төгрөгөөр нэмэгдүүллээ.</p> <p>Сумын төв зам болон Орхон хаалга, Хар морьт, Цагаан нуур, Тарвагтай хөтөл чиглэлд авто тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад 3000 тээврийн хэрэгсэл шалгаж зөрчил гаргасан 348 жолоочид 8.9 сая төгрөгийн бэлэн бусаар торгууль оногдуулж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 18, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 8 зөрчлийг илрүүлж ажилласан. Мөн цагдаагийн нэгдсэн санд эрэн сурвалжлагдаж байсан 5 иргэнийг олж тогтоож холбогдох албан тушаалтанд хүлээлгэж өгсөн.</p>			
26	3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, намрын ургац хураалтын бэлтгэлийг хангах, бусад аймаг, сумдаас ирэх отор нүүдлийг Засгийн газраас тогтоосон маршрутын дагуу мэргэжлийн байгууллагын хорио цээр, хяналт шалгалтын дор хэрэгжүүлэх, отроор өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахад анхаарч ажиллах	<p>2024 оны аюулгүйн нөөц 40 тн өвс, 6 тн хивэг бэлтгэсэн бөгөөд хаваржилт хүндрээгүй тул зарцуулаагүй нөөцлөгдөж байна.</p> <p>2025-2026 оны өвөлжилтөд 10 тн өвс, 11 тн тэжээл, 100 кг эрдэс нэмж бэлтгэлээ.</p> <p>Сумын аюулгүйн нөөцөд нийт 50 тн өвс, 17 тн тэжээл, 100 кг эрдэс байна.</p> <p>Отор нүүдлээр 11 өрхийн бод 689 толгой, бог 3019 толгой нийт 3708 толгой мал Сэлэнгэ аймгийн Жавхлант, Ерөө, Хушаат, Зүүнбүрэн, Баруунбүрэн сум болон Дорнод аймгийн Матад суманд отроор өвөлжиж байна.</p> <p>Шинэ хөдөө төслийн хүрээнд байцаа хураан авах комбайн, ургамлын сийрүүлэгч, төмсний комбайн, дамарт усалгааны систем, 130 морины хүчин чадалтай трактор, хадлангийн диск хадуур, наран тармуур, үр тариа, ногоон</p>	100	-	-	

			<p>тэжээл тариалах үрлэгч нийт 8 тоног төхөөрөмжийг хүлээн авч сумын Тохижилт Үйлчилгээ ОНӨААГазраас ашиглалт үйл ажиллагааг явуулж 40 га талбайд малын тэжээлийн тариалалт, 34 га талбайн хөрс боловсруулалт, 20 га талбайн төмс хураалт, 14 га талбайн малын тэжээлийн ургамлын хураалтыг хийсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй их дээд сургуулиудаас давхардсан тоогоор 1870 хүн хүч ургац хураалтад ажиллалаа.</p>			
33		<p>4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч ЗГ-ын зардлаар суралцаж төгссөн. Мөн “Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй” богино хугацааны сургалтад 2, албан хаагч тус тус суралцсан. Төрийн албаны зөвлөлөөс явуулж байгаа “7:4:10” арга зүйн 10 удаагийн сургалтад 11 албан хаагч хамрагдлаа.</p> <p>Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөрийг баталж, 24 албан хаагчийг Монгол бичгийн сургалтад хамруулж байна.</p>	100	-	-

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

С.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ХЭЗХМЭРГЭЖИЛТЭН

С.ХАЛИУН